



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Засаг даргын дэргэдэх статистикийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2022/154/НА/СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Чойбалсан хот

2022 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Аудитор: Ш.Мөнхцэцэг

Утас: 70003775, 99799039

Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.6.1 Төсвийн төлөвлөлт	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1. Аудитын санал дүгнэлт



**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

Г ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Д.ЭНХБААТАР

№
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Статистикийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Статистикийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ

011020930

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>5,435,126.00</u>	<u>4,435,794.00</u>
33	АВЛАГА	1,109,332.00	-
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	1,109,332.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	4,325,794.00	4,435,794.00
354	Хангамжийн материал	4,325,794.00	4,435,794.00
35420	Аж ахуйн материал	1,942,578.00	2,052,578.00
35470	Бусад хангамжийн материал	2,383,216.00	2,383,216.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>61,043,275.94</u>	<u>52,042,011.96</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	61,043,275.94	52,042,011.96
392	Биет хөрөнгө	61,043,275.94	52,042,011.96
39203	Авто-тээврийн хэрэгсэл	55,730,000.00	35,750,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(23,757,972.24)	(9,930,555.60)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	51,128,063.64	56,403,663.64
39206	Хуримтлагдсан элэгдэл	(22,243,343.56)	(30,181,096.08)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	5,490,160.00	5,490,160.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,303,631.90)	(5,490,160.00)
39214	Бусад үндсэн хөрөнгө	457,787.00	457,787.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(457,787.00)	(457,787.00)
39301	Программ хангамж	500,000.00	500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(500,000.00)	(500,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>66,478,401.94</u>	<u>56,477,805.96</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,109,332.00</u>	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,109,332.00	-
413	Өглөг	1,109,332.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,109,332.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>65,369,069.94</u>	<u>56,477,805.96</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	65,369,069.94	56,477,805.96
512	Хуримтлагдсан үр дүн	65,369,069.94	56,477,805.96
51210	Өмнөх үеийн үр дүн	65,369,069.94	65,369,069.94
51220	Тайлант үеийн үр дүн	-	(8,891,263.98)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>66,478,401.94</u>	<u>56,477,805.96</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	401,398,229.00	208,874,381.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	61,041,981.00	6,003,467.00
120	Нийтлэг татварын бус орлого	61,041,981.00	6,003,467.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	61,041,981.00	5,385,600.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	61,041,981.00	5,385,600.00
120009	Бусад орлого	-	617,867.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	340,356,248.00	202,870,914.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	103,808,600.00	106,001,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	103,808,600.00	106,001,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	236,547,648.00	96,869,914.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,000,000.00	8,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	227,547,648.00	88,869,914.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	344,284,588.48	217,765,644.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	344,284,588.48	217,765,644.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	341,616,960.15	216,873,350.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	87,291,390.40	89,591,434.00
210101	Үндсэн цалин	57,147,819.74	53,790,294.00
210102	Нэмэгдэл	21,074,897.66	28,782,637.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,357,000.00	3,996,000.00
210104	Урамшуулал	5,711,673.00	3,022,503.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,430,404.27	11,545,179.68
210201	Тэтгэврийн даатгал	10,430,404.27	8,959,330.09
210202	Тэтгэмжийн даатгал	-	795,504.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	606,163.76
210204	Ажилгүйдлийн даатгал	-	107,652.82
210205	Эрүүл мэндийн даатгал	-	1,076,528.34
2104	Хангамж, бараа материалын зардал	1,805,380.00	2,347,650.00
210401	Бичиг хэрэг	619,400.00	787,560.00
210402	Тээвэр, шатахуун	213,200.00	718,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	619,400.00	453,790.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	353,380.00	388,000.00
2107	Томилолт, зочны зардал	207,000.00	175,000.00
210702	Дотоод албан томилолт	207,000.00	175,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	233,954,445.00	98,937,223.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	233,046,469.00	98,028,983.00
210803	Даатгалын үйлчилгээ	81,676.00	198,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	39,300.00	49,340.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	19,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	787,000.00	641,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,928,340.48	14,276,863.98
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7,928,340.48	14,276,863.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,667,628.33	892,294.32
2132	Бусад урсгал шилжүүлэг	221,400.00	196,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	221,400.00	196,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,446,228.33	695,494.32
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,446,228.33	695,494.32
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	57,113,640.52	(8,891,263.98)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	57,113,640.52	(8,891,263.98)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	00.00	00.00	29,410,841.42	29,410,841.42
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	29,410,841.42	29,410,841.42
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-21,155,412.00	-21,155,412.00
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	65,369,069.94	65,369,069.94
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	65,369,069.94	65,369,069.94
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-8,891,263.98	-8,891,263.98
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	56,477,805.96	56,477,805.96

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	340,356,248.00	203,488,781.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	617,867.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	617,867.00
120009	Бусад орлого	-	617,867.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	340,356,248.00	202,870,914.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	103,808,600.00	106,001,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	103,808,600.00	106,001,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	236,547,648.00	96,869,914.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,000,000.00	8,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	227,547,648.00	88,869,914.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	340,356,248.00	203,488,781.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	340,356,248.00	203,488,781.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	337,664,019.67	202,596,486.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	87,900,142.40	89,866,922.00
210101	Үндсэн цалин	56,692,282.74	54,044,541.00
210102	Нэмэгдэл	19,299,187.66	29,115,327.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,357,000.00	3,941,206.00
210104	Урамшуулал	8,551,672.00	2,765,848.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,321,652.27	11,506,244.68
210201	Тэтгэврийн даатгал	10,321,652.27	8,440,791.75
210202	Тэтгэмжийн даатгал	-	939,922.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	718,336.72
210204	Ажилгүйдлийн даатгал	-	127,926.72
210205	Эрүүл мэндийн даатгал	-	1,279,267.42
2104	Хангамж, бараа материалын зардал	2,437,180.00	2,407,200.00
210401	Бичиг хэрэг	509,400.00	774,400.00
210402	Тээвэр, шатахуун	845,000.00	718,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	619,400.00	526,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	463,380.00	388,000.00
2107	Томилолт, зочны зардал	207,000.00	175,000.00
210702	Дотоод албан томилолт	207,000.00	175,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	236,798,045.00	98,641,120.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	235,890,069.00	97,654,580.00
210803	Даатгалын үйлчилгээ	81,676.00	198,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	39,300.00	49,340.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	19,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	787,000.00	719,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,692,228.33	892,294.32
2132	Бусад урсгал шилжүүлэг	246,000.00	196,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	246,000.00	196,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,446,228.33	695,494.32
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,446,228.33	695,494.32
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	106,001,000.00	105,333,506.68	667,493.32	99.4%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	106,001,000.00	105,333,506.68	667,493.32	99.4%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	105,804,200.00	105,136,706.68	667,493.32	99.4%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	89,867,600.00	89,866,922.00	678.00	100.0%
210101	Үндсэн цалин	59,584,800.00	54,044,541.00	5,540,259.00	90.7%
210102	Нэмэгдэл	21,120,700.00	29,115,327.00	(7,994,627.00)	137.9%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,579,200.00	3,941,206.00	637,994.00	86.1%
210104	Урамшуулал	4,582,900.00	2,765,848.00	1,817,052.00	60.4%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	12,132,100.00	11,506,244.68	625,855.32	94.8%
210201	Тэтгэврийн даатгал	8,537,400.00	8,440,791.75	96,608.25	98.9%
210202	Тэтгэмжийн даатгал	898,700.00	939,922.07	(41,222.07)	104.6%
210203	ҮОМШӨ-ний даатгал	718,900.00	718,336.72	563.28	99.9%
210204	Ажилгүйдлийн даатгал	179,700.00	127,926.72	51,773.28	71.2%
210205	Эрүүл мэндийн даатгал	1,797,400.00	1,279,267.42	518,132.58	71.2%
2104	Хангамж, бараа материалын зардал	2,129,900.00	2,407,200.00	(277,300.00)	113.0%
210401	Бичиг хэрэг	497,100.00	774,400.00	(277,300.00)	155.8%
210402	Тээвэр, шатахуун	718,200.00	718,300.00	(100.00)	100.0%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	526,500.00	526,500.00	-	100.0%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	388,100.00	388,000.00	100.00	100.0%
2107	Томилолт, зочны зардал	197,800.00	175,000.00	22,800.00	88.5%
210702	Дотоод албан томилолт	197,800.00	175,000.00	22,800.00	88.5%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,181,500.00	1,181,340.00	160.00	100.0%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	194,800.00	194,800.00	-	100.0%
210803	Даатгалын үйлчилгээ	198,000.00	198,000.00	-	100.0%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	49,500.00	49,340.00	160.00	99.7%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	19,800.00	19,800.00	-	100.0%
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	719,400.00	719,400.00	-	100.0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	295,300.00	-	295,300.00	0.0%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	295,300.00	-	295,300.00	0.0%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	196,800.00	196,800.00	-	100.0%
2132	Бусад урсгал шилжүүлэг	196,800.00	196,800.00	-	100.0%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	196,800.00	196,800.00	-	100.0%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	106,001,000.00	105,333,506.68	667,493.32	99.4%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	106,001,000.00	105,333,506.68	667,493.32	99.4%
131001	Улсын төсвөөс санхүүжих	106,001,000.00	105,333,506.68	667,493.32	99.4%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	

5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	7	7	-	100.0%
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	4	4	-	100.0%
620004	Гэрээт ажилтан	2	2	-	100.0%

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	97,487,781.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	97,487,781.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	97,459,780.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	97,459,780.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	97,459,780.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	28,001.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	28,001.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	97,487,781.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	97,487,781.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	88,869,914.00
14	Бусад эх үүсвэр	617,867.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Засаг даргын дэргэдэх статистикийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд МУ-ын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын хэрэгжилт болон зардлын ангиллын талаарх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Хаан консалтинг аудит ХХК-ийн аудитор Г.Ганцэцэг, хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Засаг даргын дэргэдэх статистикийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 17 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл нь: Бид Монгол Улсын статистик мэдээллийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр эрхлэн гаргаж, хэрэглэгчдэд адил тэгш үйлчилнэ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй боловч 2018 онд Дорнод аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан “Дорнод аймгийн төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллага нь хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын нэгжгүй бөгөөд хяналтыг байгууллагын удирдлага хэрэгжүүлэн ажилладаг байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Засаг даргын дэргэдэх статистикийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл

баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 төсвийн гүйцэтгэлийн тайлангаас сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны батлагдсан төсөвт зардлын дүн 101,520.0 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 2,030.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 1,522.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бараа материалын дансны үлдэгдэл 4,435.8 мянган төгрөг болж 110.0 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авалттай холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 98,601.6 мянган төгрөг болж 14,704.4 мянган төгрөгөөр буурсан байна. Үндсэн хөрөнгийн данс нь 5,275.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж шилжүүлж авснаар нэмэгдэн, 19,980.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслээр хасагдсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 192,523.8 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь орон нутгаас хуваарилсан мөнгөн хөрөнгөтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 126,519.0 мянган төгрөгөөр буурсан нь бараа, ажил үйлчилгээний зардал буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 106,001.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 106,001.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 106,001.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 106,001.0 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 106,001.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 106,001.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд бүрэн зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 105,333.5 мянган төгрөг буюу 99.4 хувийн гүйцэтгэлтэй буюу 667.5 мянган төгрөгийн татан төвлөрүүлэх хийгдсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дорнод аймгийн дээд шатны төсвийн захирагчаас 88,869.9 мянган төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгөөс 8,000.0 мянган төгрөг, бусад эх үүсвэрээс 617.9 мянган төгрөг, нийт 97,487.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил гүйлгээний төлбөр хураамжийн зардалд 97,459.8 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос зарцуулж, 28.0 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ, үйл явдал гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Засаг даргын дэргэдэх статистикийн газар нь 2021 онд Шилэн дансны мэдээллийн тулгалтаар цахим хуудсанд бүх мэдээллийг хуулийн хугацаанд мэдүүлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Монгол улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17 -ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.1-д “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасны дагуу бүх шатны

байгууллагын төсөв захирагч буюу эрхлэгч тушаал шийдвэр гаргаж хэрэгжилтийг ханган ажиллаагүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 37 сая төгрөгийн 2 албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Нягтлан бодох бүртгэлийг хөтлөхдөө 2018 онд хэвлэгдсэн Дорнод аймгийн төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж хэрэгжүүлэх
- Дорнод аймгийн Засаг даргын тамгын газраас гаргасан Санхүү, төсвийн холбогдолтой дүрэм, журмын эмхэтгэлийн дагуу хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг ханган ажиллах

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 12,083.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2,149.7 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 9,933.5 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

4.1 Албан шаардлага

1. Зардлын эдийн засгийн ангиллыг шилжүүлэн 2,149.7 мянган төгрөгийн зардал хоорондын гүйлгээний бичилт хийсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах, Сангийн сайдын 2021 оны 10 сарын 29 өдрийн 190 дугаар тушаалын хавсралт Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавартай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь : Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг бүрэн мөрдөх, зардал хоорондын гүйлгээ бичилт хийхгүй байх, Албан шаардлага өгөх

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд :

1. Зардлын хэмнэлттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт : МУ-ын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.1 "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах " зүйл заалтын хэрэгжилтийг хангаж удирдлагаас тушаал шийдвэр гаргаж ажиллаагүй.

1.2 Өгсөн зөвлөмж : Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д " төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнана " гэж заасны дагуу төсвийн хэмнэлтийг гаргах тушаал гаргаж, хэрэгжилтийг ханган ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 5 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Засаг даргын дэргэдэх статистикийн газар	2	12.0	-	-	-	-	1	2.1	1	9.9